

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Баяннуур сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/33/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: С.Нурлан

Утас: 94209011 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл .....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Байхгүй.....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.3 Албан шаардлага .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.4 Зөвлөмж.....	<b>Error! Bookmark not defined.</b>
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

**БАЯННУУР СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Х.ТОЙЛЫБАЙ ТАНАА**

2022.02.25 № 189  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяннуур сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяннуур сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Dugnelt-TA

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



Dugnelt-TA

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Төгрөгөөр Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>31,942,178.79</u></b>	<b><u>27,071,087.22</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	3,155,942.57	174,773.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,981,169.57	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	174,773.00	174,773.00
3351	Байгууллагаас авах авлага	174,773.00	174,773.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	28,786,236.22	26,896,314.22
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	28,786,236.22	26,896,314.22
35410	Бичиг хэргийн материал	847,900.00	835,100.00
35420	Аж ахуйн материал	20,784,854.00	21,514,912.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	-
35440	Түлш, шатах тослох материал	2,846,373.29	1,179,623.29
35450	Барилгын засварын материал	-	124,000.00
35460	Хүнсний материал	4,050,108.93	2,104,678.93
35470	Бусад хангамжийн материал	257,000.00	1,138,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>119,197,065.42</u></b>	<b><u>109,266,028.83</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	119,197,065.42	109,266,028.83
391	Газар	-	-
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	89,197,065.42	79,266,028.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	71,129,400.00	71,129,400.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(9,722,576.08)	(19,172,280.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	31,929,876.00	31,929,876.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,933,084.39)	(28,589,167.59)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,412,982.00	40,323,107.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	(29,739,645.13)	(30,141,669.07)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,540,200.00	14,788,900.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		

		(3,112,005.23)	(4,694,055.26)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	-
39217	Ном	3,691,918.25	3,691,918.25
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	30,000,000.00	30,000,000.00
39301	Програм хангамж	275,000.00	275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(275,000.00)	(275,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	30,000,000.00	30,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>151,139,244.21</u></b>	<b><u>136,337,116.05</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>341,100.00</u></b>	<b><u>315,822.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	341,100.00	315,822.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	341,100.00	315,822.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	306,912.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	341,100.00	8,910.00
41361	Байгууллагад төлөх өглөг	257,000.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	84,100.00	8,910.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>150,798,144.21</u></b>	<b><u>136,021,294.05</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	150,798,144.21	136,021,294.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	89,898,883.00	89,898,883.00
51101	Өмч: - төрийн	89,898,883.00	89,898,883.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	458,111.86	(14,233,978.30)
51210	Өмнөх үеийн үр дүн	458,111.86	542,871.86
51220	Тайлант үеийн үр дүн	-	(14,776,850.16)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	60,441,149.35	60,356,389.35
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>151,139,244.21</u></b>	<b><u>136,337,116.05</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>291,414,276.00</b>	<b>293,197,633.00</b>

<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,793,176.00</b>	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,793,176.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,793,176.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,793,176.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>289,621,100.00</b>	<b>293,197,633.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	277,556,300.00	275,694,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	277,556,300.00	275,694,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	4,421,733.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,421,733.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	12,064,800.00	13,081,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12,064,800.00	13,081,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>326,834,402.63</b>	<b>307,974,483.16</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>326,834,402.63</b>	<b>307,974,483.16</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	314,371,612.63	294,745,655.16
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	231,231,585.00	220,631,036.00
210101	Үндсэн цалин	231,231,585.00	196,648,436.00
210102	Нэмэгдэл	-	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	-	10,369,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	13,613,400.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	-	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,153,598.43	28,772,445.57
210201	Тэтгэврийн даатгал	29,153,598.43	28,772,445.57
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9,818,550.00	10,108,750.00
210301	Гэрэл, цахилгаан	1,263,700.00	1,264,000.00
210302	Түлш, халаалт	8,554,850.00	8,844,750.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,194,935.00	3,323,202.00
210401	Бичиг хэрэг	482,600.00	150,700.00
210402	Тээвэр, шатахуун		

		1,102,600.00	1,575,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	673,000.00	528,100.00
210404	Ном, хэвлэл	171,700.00	66,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	765,035.00	385,700.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	-
210408	Бараа материал акталсны зардал	-	617,302.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	11,356,580.00	16,400,485.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	184,500.00	82,600.00
210502	Хоол, хүнс	10,812,080.00	15,759,285.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	360,000.00	558,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	376,000.00
210604	Урсгал засвар	-	376,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	152,400.00
210702	Дотоод албан томилолт	-	152,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	389,500.00	470,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	125,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	389,500.00	345,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	29,226,864.20	14,510,736.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,671,200.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,199,210.00	331,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,356,454.20	14,179,736.59
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	12,462,790.00	13,228,828.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,821,800.00	8,655,045.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,821,800.00	8,655,045.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	6,437,890.00	434,783.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,437,890.00	434,783.00
213304	Хөрөнгийн	-	-

<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	2,203,100.00	4,139,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,203,100.00	4,139,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(35,420,126.63)</u></b>	<b><u>(14,776,850.16)</u></b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	4,671,200.00	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	4,671,200.00	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	4,671,200.00	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(30,748,926.63)</u></b>	<b><u>(14,776,850.16)</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>289621100.00</u></b>	<b><u>293197633.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>289621100.00</b>	<b>293197633.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	277556300.00	275694900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	277556300.00	275694900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	4421733.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	4421733.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	12064800.00	13081000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12064800.00	13081000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>289228100.00</u></b>	<b><u>288948933.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>289228100.00</b>	<b>288948933.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>276765310.00</b>	<b>277424250.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	219721980.00	216761500.00
210101	Үндсэн цалин	187692200.00	192684779.00
210104	Урамшуулал	16823580.00	10463321.00
210105	Гэрээт ажлын хөлс	15206200.00	13613400.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30228320.00	29353900.00
210201	Тэтгэврийн даатгал	20920900.00	20656500.00
210202	Тэтгэмжийн даатгал	2234000.00	2174300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1617500.00	1739500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1051520.00	434800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4404400.00	4348800.00

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9861700.00	8442000.00
210301	Гэрэл, цахилгаан	1263700.00	1264000.00
210302	Түлш, халаалт	8598000.00	7178000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3483800.00	3294200.00
210401	Бичиг хэрэг	415100.00	133300.00
210402	Тээвэр, шатахуун	1260100.00	1575000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	673000.00	811100.00
210404	Ном, хэвлэл	171700.00	190400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	963900.00	584400.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	11863800.00	16589650.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	110700.00	123300.00
210502	Хоол, хүнс	10293100.00	15669350.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1460000.00	797000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	0.00	500000.00
210604	Урсгал засвар	0.00	500000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	0.00	152400.00
210702	Дотоод албан томилолт	0.00	152400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	389500.00	535600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	190100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	389500.00	345500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1216210.00	1795000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	160000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1216210.00	1635000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12462790.00</b>	<b>11524683.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3821800.00	6950900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3821800.00	6950900.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	6437890.00	434783.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6437890.00	434783.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	2203100.00	4139000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2203100.00	4139000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>393000.00</u></b>	<b><u>4248700.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>393000.00</b>	<b>4248700.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>393000.00</b>	<b>4248700.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	393000.00	4248700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	393000.00	4248700.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-393000.00</u></b>	<b><u>-4248700.00</u></b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	89,898,883.00	60,441,149.35	458,111.86	150,798,144.21
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	89,898,883.00	60,441,149.35	458,111.86	150,798,144.21
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			84,760.00	84,760.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	89,898,883.00	60,441,149.35	542,871.86	150,882,904.21
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	-84,760.00	0.00	-84,760.00
D08	Тайлант үеийн үр дүн			-14,776,850.16	-14,776,850.16
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	89,898,883.00	60,356,389.35	-14,233,978.30	136,021,294.05

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	288785900.00	284215150.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	288785900.00	284215150.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	281835000.00	277264250.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	216768400.00	216761500.00
210101	Үндсэн цалин	192785800.00	192684779.00
210102	Нэмэгдэл	0.00	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		

210104	Урамшуулал	10369200.00	10463321.00
210105	Гэрээт ажлын хөлс	13613400.00	13613400.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29353900.00	29353900.00
210201	Тэтгэврийн даатгал	20656500.00	20656500.00
210202	Тэтгэмжийн даатгал	2174300.00	2174300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1739500.00	1739500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	434800.00	434800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4348800.00	4348800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12581000.00	8442000.00
210301	Гэрэл, цахилгаан	1264000.00	1264000.00
210302	Түлш, халаалт	11317000.00	7178000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3328200.00	3294200.00
210401	Бичиг хэрэг	133300.00	133300.00
210402	Тээвэр, шатахуун	1575000.00	1575000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	811100.00	811100.00
210404	Ном, хэвлэл	190400.00	190400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	618400.00	584400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	16922900.00	16589650.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	123300.00	123300.00
210502	Хоол, хүнс	16002600.00	15669350.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	797000.00	797000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	500000.00	500000.00
210604	Урсгал засвар	500000.00	500000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	152400.00	152400.00
210702	Дотоод албан томилолт	152400.00	152400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	590400.00	535600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	190400.00	190100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400000.00	345500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1637800.00	1635000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1637800.00	1635000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	6950900.00	6950900.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	6950900.00	6950900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6950900.00	6950900.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	288775900.00	284215150.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	288775900.00	284215150.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	275694900.00	275273150.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	13081000.00	8942000.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	19.00	19.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00
620004	Гэрээт ажилтан	3.00	3.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>19.0</b>	<b>19.0</b>

650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	8.00	8.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	8.00
650010	Гэрээт ажилтан	3.00	3.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>4408700.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>4408700.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.00	4408700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	4408700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	4408700.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	4421733.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	4421733.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4421733.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баяннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Баяннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Баяннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь хүүхдийн эрхийг дээдэлсэн, сурагчдад стандартаар тогтоосон бага боловсрол олгох, эзэмшүүлэх, сургалтын хөтөлбөрийн агуулгыг баяжуулах, багшийг чадавхжуулах замаар сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх, хүүхэд бүрийг хөгжүүлэх, хүүхдийг төлөвшүүлэх, бие даан сурах хүсэл тэмүүлэлтэй хүүхдүүд бэлтгэхэд оршино..

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус албанаас сургуулийн 2021 оны үйл ажиллагаанд баримтын шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяннуур сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшин 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 293.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 4.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баяннуур сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 14.8 сая төгрөгөөр буюу 10.9 хувиар буурсан байна. Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авллага	3,155.9	174.7	-2,981.1

Урьдчилгаа	0.0	0.0	0.00
Бараа материал	28,786.2	26,896.3	1,889.9
Үндсэн хөрөнгө	189,979.3	109,266.0	-80,713.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>151,139.2</b>	<b>136,337.1</b>	<b>-14,802.1</b>
Өр төлбөр	341.1	315.8	-25.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	150,798.1	136,021.3	-14,776.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>151,139.2</b>	<b>136,337.1</b>	<b>-14,802.1</b>

Мөнгөн хөрөнгийн данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Авлагын дансны эцсийн үлдэгдэл нь 0.2 сая төгрөг болж, 2.9 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 26.9 сая төгрөг болж 1.9 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 33.0 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаандаа 34.3 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 80.7 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 4.2 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 2.3 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасаж, үндсэн хөрөнгөд 14.2 сая төгрөгийн элэгдэл байгуулжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 0.3 сая төгрөг болж буурсан нь тайлант онд 0.03 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 136.0 сая төгрөг болж 14.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 14.8 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1.8 сая төгрөгөөр буюу 0.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан нь төсвийн санхүүжилттэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 18.7 сая төгрөгөөр буюу 5.8 хувиар буурсан байна. Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан цалин, хангамж бараа материал, бараа үйлчилгээний бусад зардал байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны анх батлагдсан төсөв 294.2 сая төгрөг, тодотгосон төсөв 288.8 сая төгрөг байна.

Тодотголоор анх баталсан төсөв 8.9 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд: Цалин хөлс болон НДШ-ийн зардал 11.8 сая төгрөгөөр нэмэгдэж, хоол, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 20.7 сая төгрөгөөр буурсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 288.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 284.2 сая төгрөгийг зарцуулжээ. Батлагдсан төсвөөс 0.4 сая төгрөгийн санхүүжилт дутуу авч, 4.1 сая төгрөгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Нийт төсвийн 76.2 хувийг цалин, 10.3 хувийг НДШ-ийн зардал, 2.9 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 1.1 хувийг хангамж, бараа материалын зардал, 5.8 хувийг норматив зардал, 0.2 хувийг эд хогшил худалдан авах зардал, 0.05 хувийг томилолт, зочны зардал, 0.18 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний зардал 0.6 хувийг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг 2.4 хувийг тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 4.4 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авч бараа үйлчилгээний бусад зардалд 4.4 сая төгрөгийг зарцуулж 13.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэн шилжүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Баяннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой мэдээллүүдийг бүрэн толилуулан, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Баяннуур сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь 2021 онд төсвийн гүйцэтгэлээр нийт 284.2 сая төгрөгийн төсөв зарцуулж 4.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн бөгөөд үүнээс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлыг хасахад бусад тэвчиж болох зардал зардал 7.1 сая төгрөгийн 10 хувь 0.7 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байгаа ба оны эцэст 4.5 сая төгрөгийн хэмнэлтийг төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнээс үзэхэд Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдсан гэж үзлээ.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэхүйц асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баяннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 онд нийт 257.2 сая төгрөгийн 119 мэдээллийг тус байгууллагын шилэн дансны тайлан илгээх маягтаар хянаж үзэхэд мэдээлсэн 106, хугацаа хоцроосон 11 мэдээлэл, 2 мэдээллийн хугацаа болоогүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг байгууллагын хэрэгжилтэд хийсэн аудитын дүнгийн маягтаар мэдээлсэн 90.0 хувь, мэдээлээгүй 10 хувь, нийт шилэн дансны хэрэгжилт 90.0 хувийн хэрэгжилттэй байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 15.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 0.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 11.2 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 3.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдлөө.

### **4.1 Залруулсан алдаа**

Байхгүй

#### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар 0.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

1. Сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолонд өдөр бүрийн хоолны талоны дүнгээр нийт 4401 хүүхдэд 15,838.5 мянган төгрөгийн хүнсний материал зарцуулсан бөгөөд Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор батлагдсан хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын нормоор тооцож үзэхэд жилийн дүнгээр батлагдсан нормыг 545.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн төсвөөс хууль бус зарлага гаргасан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийг дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор баталсан “Хоолны зардлын норматив тогтоох тухай” журмын 2-т “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 3475 төгрөгөөр тогтоосугай” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах акт тогтоов.

#### 4.3 Албан шаардлага

Аудитаар 11.1 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв. Үүнд:

1. Бараа материалын тодруулга тайлан, нярвын материалын тайлангийн орлого, зарлагын гүйлгээг тулган шалгахад хүнсний материалын орлого тодруулга тайланд 20.7 сая төгрөг, нярвын тайланд 16.3 сая төгрөг бөгөөд 4.4 сая төгрөгөөр дутуу, Хүнсний материалын зарлага тодруулга тайланд 22.6 сая төгрөг, нярвын тайланд 15.9 сая төгрөг бөгөөд 6.7 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан.

Харилцах данснаас хоолны зардалд шилжүүлсэн зарлагын гүйлгээг нярвын тайлангийн орлогын падаанаар тулгаж үзэхэд хүнсний материалын орлогыг 4.4 сая төгрөгөөр дутуу тайлагнасан. Аж ахуйн материалын тайлангийн анхан шатны баримтын хөтлөлт, бүрдүүлэлт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.3-д “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, 14.3.1-д “анхан шатны баримт бүрдүүлэх”, 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Шилэн дансны хэрэгжилтэй холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Баяннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны шилэн дансны мэдээллийг шилэн дансны тайлан илгээх маягтаар хянаж үзэхэд мэдээлсэн 106, мэдээлээгүй 2, хугацаа хоцроосон 11 үзүүлэлтэй, шилэн дансны хэрэгжилт 90.0 хувьтай байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх.

**2. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, талагналтай холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт:

Тайлан онд хангамж, бараа материалын зардалд 0.6 сая төгрөг, норматив зардал 0.6 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 1.3 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжын зардалд 0.5 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 0.3 сая төгрөг, томилолтын зардал, норматив зардалд 0.1 сая төгрөг, нийт 3.4 сая төгрөгийн зардлыг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.2, 14.3.3, 20.2, 20.2.5, 20.2.6 дахь заалтуудыг мөрдөж худалдан авсан бараа материалыг шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Баяннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль	4	15			1	0.5	1	11.1	2	3.4

/сая төгрөгөөр/